



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/43

Баянтал сум

Хязгаарлалтын дэглэмийг
тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4, 15.5, 17 дугаар зүйлийн 17.2, 17.3, 19 дүгээр зүйлийн 19.1, Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоолын "Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам"-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн голомтын бүсийг 7 км, сэжигтэй бүсийг 10 км, хамгаалалтын бүсийг 13 км тогтоож 21 хоногийн хугацаатай хязгаарлалтын дэглэмийг тогтоосугай.

2.Хязгаарлалтын дэглэм тогтоосонтой холбогдуулан ерөнхий зохион байгуулалтаар хангаж ажиллахыг сумын Онцгой комиссын орлогч дарга (Э.Эрхэмбаатар)-д даалгасугай.

3.Малын гоц халдварт цэцэг өвчин Баянтал сумын хил залгаа Сүмбэр сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэр Тэрэгтэд гарсан тул уг өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж хүн, мал, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах, хяналт тавих зорилгоор Лүнгийн ар талд хяналтын пост байгуулсугай.

4.Малчин өрхийн отор нүүдэл, малын шилжилт хөдөлгөөний нөхцөл байдалтай тандалт хийж, малын эмчийн зөвшөөрөлгүй отор нүүдэл, шилжилт хөдөлгөөн хийлгэхгүй байх, гадны аймаг сумдаас отор нүүдлээр хээлтүүлэгч мал, хурдан морь, бусад мал амьтан худалдаж авахгүй байхыг анхааруулж мэдэгдэхийг 1 дүгээр багийн Засаг дарга (Э.Түмэн-Эрдэнэ), малын хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг "Хилийн Дэлгэрэх" ХХК-ний малын их эмч (Л.Сүрэнсугир), Хөдөө аж ахуйн тасгийн Бэлчээр газар тариалан, худаг мал аж ахуйн технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн (Т.Эрдэнэбаяр) нарт үүрэг болгосугай.

5.Хязгаарлалтын дэглэмийн хугацаанд хяналтын постод ажиллах мэргэжлийн багийг 1 дүгээр хавсралтаар, сэжигтэй бүсэд байгаа малчин өрхийн зураглалыг 2 дугаар хавсралтаар, төв штаб дээр ажиллах албан хаагчдын нэрсийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

6.Малын гоц халдварт өвчнөөс сэргийлэх, уг ажлыг зохион байгуулах, хяналтын пост ажиллуулахад шаардлагатай бусад зардлын тооцоог гаргаж, хяналт тавин ажиллахыг Санхүү албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Отгонпүрэв)-д үүрэг болгосугай.

7.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж сумын онцгой комиссын штабыг өдөр тутмын шуурхай үүрэг, удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Э.ЭРХЭМБААТАР)-д даалгасугай.

ДАРГА

Б.ГАНБАЯР

Сумын Засаг даргын 2023 оны
05 дугаар сарын 2-дний 1 дугаар
захирамжийн 2-дүгээр хавсралт

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН БАЯНТАЛ СУМЫН ЛҮНБАГИЙН
ГОЛОМТОД ОЙР БАЙГАА МАЛТАЙ ӨРХИЙН
СУДАЛГАА

| | Овог нэр | Регистрийн дугаар | Бүгд | Тэмээ | Адуу | Үхэр | Хонь | Ямаа | 2023 он утасны дугаар |
|----|----------------|----------------------|------|-------|------|------|------|------|-----------------------------|
| 1 | Л.Эрхэмбаяр | 3370022315 | 569 | | 35 | 3 | 255 | 276 | 86968224 |
| 2 | Б.Мянганбаяр | ОК77082913 | 1076 | | 29 | 434 | 534 | 79 | 99645551 |
| 3 | Д.Галсандорж | ЗП77052453 | 574 | | 54 | 27 | 269 | 224 | 99454977 |
| 4 | Н.Жанцан | ЕЕ56100319 | 234 | | | 7 | 49 | 178 | 85827004 |
| 5 | Ж.Рэгзэнсүрэн | ЗН95021516 | 472 | | | | 110 | 362 | 88226824 |
| 6 | Ж.Батсүрэн | ЕЙ65110515 | 1014 | | 53 | 123 | 723 | 115 | 88856569 |
| 7 | А.Амгалан | ГЮ71120118 | 368 | | 29 | 45 | 146 | 148 | 99540614 |
| 8 | Д.Оюунбилэг | ЗН59013012 | 995 | | | 16 | 797 | 182 | 99781635 |
| 9 | Л.Банди | ЗМ54011716 | 605 | | 25 | 30 | 300 | 250 | 88981587 |
| 10 | Р.Холтсонцэцэг | ЗН59072702 | 188 | | | 33 | 71 | 84 | 95126058 |
| 11 | Р.Даваахүү | ЕЙ78112717 | 293 | | | 13 | 147 | 133 | 88577317 |
| 12 | Р.Гангаамаа | ЗН63101017 | 32 | | 5 | 7 | 10 | 10 | 90330490 |
| | НИЙТ ДҮН | | 7141 | 0 | 325 | 749 | 3610 | 2462 | |

СУДАЛГАА ГАРГАСАН

ЛҮН БАГИЙН ЗАСАГ ДАРГА  Э.ТҮМЭН-ЭРДЭНЭ

Сумын Засаг даргын 2023 оны
05 дугаар сарын 2 өдрийн 4 дугаар
захирамжийн 3 дугаар хавсралт

Хорио цээрийн дэглэмийн үед төв штаб дээр ажиллах
албан хаагчдын нэрс

| № | Он,сар, өдөр | Харицах албан байгууллагууд | Хариуцах эзэн | Холбоо барих утасны дугаар |
|---|--------------------------|---------------------------------|----------------------------------|-------------------------------|
| 1 | 2023.05.03 2023.05.04 | Засаг даргын Тамгын газар | Тамгын газрын дарга В.Гантуяа | 94113190 |
| 2 | 2023.05.05 2023.05.06 | Ерөнхий боловсролын сургууль | Захирал Л.Цэрэнням | 99701303 |
| 3 | 2023.05.07 2023.05.08 | Цэцэрлэг | Эрхлэгч Б.Энхмэнд | 99033413 |
| 4 | 2023.05.09 2023.05.10 | Хүн –Эмнэлэг | Эрхлэгч Э.Баасангарав | 89290331 |
| 5 | 2023.05.11 2023.05.12 | Талын Илч ОНӨААТҮГ | Дарга А.Батжаргал | 99059086 |
| 6 | 2023.05.13 2023.05.14 | Засаг даргын Тамгын газар | Тамгын газрын дарга В.Гантуяа | 94113190 |
| 7 | 2023.05.15 2023.05.16 | Ерөнхий боловсролын сургууль | Захирал Л.Цэрэнням | 99701303 |



ГОУВСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/44

Баянтал сум

Хяналтын цэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоолоор батлагдсан “Хорио цээр хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам”-ын 4.2 дахь заалт, Сумын засаг даргын А/43 тоот захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Малын халдварт хонины цэцэг өвчний шинж тэмдэг илэрч хязгаарлалтын дэглэм тогтоосон байршилд тасралтгүй ажиллагаатай хяналтын 1 цэг байгуулсугай.

2. Хяналтын цэгт ажиллах албан хаагчдыг 1 дүгээр хавсралтаар баталсугай

3. Хяналтын цэгт ажиллах албан хаагчдыг мэргэжлийн байгууллага болох Онцгой байдлын газар, Аймгийн Цагдаагийн хэлтэстэй хамтран томилгоожуулж хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Э.Эрхэмбаатар)-д даалгасугай.

4. Хязгаарлалтын бүсээс мал амьтан, хүн тээврийн хэрэгсэлийг гаргахгүй байх, сэжигтэй бүсээр дамжин өнгөрөх, хүн тээврийн хэрэгслийг халваргүйжүүлэлтэд хамруулан нэвгрүүлэх, эргүүл хяналтыг хариуцлагатай хийж гүйцэтгэн мэдээ мэдээллээ өдөр бүр сумын шуурхай штабд тайлагнахыг хяналтын цэгт ажиллаж буй албан хаагч нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ГАНБАЯР



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/45

Баянтал сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 5.4.2 дах зүйлийн 5.4.2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Асгат овогтой Жимээдоогийн Батсүрэн нь (ЕЙ65110515) 1 дүгээр баг, Бүдүүний энгэрийн бууц хаягтай Өвөлжөө, хаваржааны зориулалтай 0.07 га (700 метр квадрат) газрын газар эзэмших эрхийг шилжүүлэх хүсэлт гаргасан тул иргэн Шавь овогтой Цэндбаярын Хишигдэлгэр (ЗП87093027)-д 15 жилийн хугацаатайгаар газар эзэмших эрхийг шилжүүлсүгэй.

2. Хуулийн дагуу ашиглаж буй газрынхаа орчны тохижилтыг сайжруулж, зүй зохистой ашиглахыг газар эзэмшигч (Ц.Хишигдэлгэр)-т үүрэг болгосугай.

3. Газар эзэмших эрхийг хуулийн дагуу авч (Ц.Хишигдэлгэр)-т газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Г.Үүрийнцолмон)-д үүрэг болгосугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2014 оны А/55 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Б.ГАНБАЯР



ДӨВӨСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/46

Баянтал сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 5.4.2 дах зүйлийн 5.4.2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Шар овогтой Ишдоржийн Доржсүрэн нь (ЗН59030111) 1 дүгээр баг, Хатуу хучилтай автозамын хойд талд, засмалын баруун талд байршилтай худалдаа, үйлчилгээний зориулалтай 0.12 га (1200 метр квадрат) газрын газар эзэмших эрхийг шилжүүлэх хүсэлт гаргасан тул иргэн Боржигон овогтой Цэвэвдоогийн Мөнх-Эрдэнэ (ЕЙ77042717)-д шилжүүлж 15 жилийн хугацаатайгаар газар эзэмших эрхийг шилжүүлсүгэй.

2. Хуулийн дагуу ашиглаж буй газрынхаа орчны тохижилтыг сайжруулж, зүй зохистой ашиглахыг газар эзэмшигч (Ц.Мөнх-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3. Газар эзэмших эрхийг хуулийн дагуу авч (Ц.Мөнх-Эрдэнэ)-д газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Г.Үүрийнцолмон)-д үүрэг болгосугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2023 оны А/20 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Б. ГАНБАЯР



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 03 өдөр

Дугаар

А/44

Баянтал сум

Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6, 4.1.7, 18 дугаар зүйлийн 18.3, 18.4, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, тээвэр, тууврын замд саатуулж, хорио цээрийн хяналтад авах журмын 5.1.4, 5.1.7 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн А/279 тоот "Отор, нүүдлийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлаж, хяналт тавих тухай" захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Баянтал сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэр "Гэээгийн бууц" хэмээх газарт малчин Ц.Даваадоржийн хотонд 2023 оны 04 дүгээр сарын 2-ны өдөр Сэлэнгэ аймгийн Хушаат сумын 2 дугаар багийн малчин Мөнхбатын сууриас 2 настай, Герфорд үүлдрийн өсвөр насны бух мал эмнэлгийн гэрчилгээгүй, мал, амьтны эрүүл мэндийн бүртгэлийн дэвтэргүй ирсэн тул 2023 оны 04 дүгээр сарын 23-ны өдрөөс 2023 оны 05 дугаар сарын 06-ны өдөр хүртэл хугацаанд хязгаарлалтын дэглэм тогтоосугай.

1.Тус нутаг дэвсгэрт хязгаарлалт тогтоож, малын шилжилт хөдөлгөөн, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн гаргах, оруулах зэргийг хориглож ажиллахыг Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч (Х.Баярцэнгэл), 1 дүгээр багийн Засаг дарга (Э.Түмэн-Эрдэнэ) нарт даалгасугай.

2.Хязгаарлалт тогтоосон нутаг дэвсгэр дэх малд үзлэг хийх, хашаа хорооны ариутгал халдваргүйтгэл хийхийг "Хилийн дэлгэрэх" мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч (Л.Сүрэнсугир)-д даалгасугай.

3.Хязгаарлалтын дэглэм тогтоосон газар, бэлчээрийн ойролцоо байгаа малчин, мал бүхий иргэд хязгаарлалтын дэглэмийг мөрдөх, захирамжийн биелэлтэнд хяналт тавьж, үүрэг чиглэл өгч ажиллахыг Засаг даргын орлогч (Э.Эрхэмбаатар)-д даалгасугай.

ДАРГА

Б.ГАНБАЯР



ТӨВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/148


Баянтал сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Баяр наадам”-ын тохижилтын ажлын зураг төсөв хийлгэх ажлын төлбөрт 5000000 / таван сая / төгрөгийг зарцуулсугай.
2. Уг арга хэмжээний зардлыг Орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулахыг Санхүү албаны нягтлан бодогч /Б.Солонгормаа/-д зөвшөөрсүгэй.
3. Дээрх ажилд хяналт тавьх ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга /В.Гантуяа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ГАНБАЯР



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 24 өдөр

Дугаар 1/49

Баянтал сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16.1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн 58 дугаар зарлигийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилж буй “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөнийг сумын хэмжээнд дунд хугацааны төлөвлөгөө гарган төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, иргэдтэй хамтран хэрэгжүүлж, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллаж үр дүнг тайлагнах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Гишүүд:

Э.Эрхэмбаатар(Сумын Засаг даргын Орлогч)
В.Гантуяа(Засаг даргын Тамгын газрын дарга)
Э.Түмэн-Эрдэнэ (Лүн багийн Засаг дарга)
Т.Ган-Эрдэнэ (Их-Уул багийн Засаг дарга)
Э.Баасангарав(Эрүүл мэндийн төвийн даргын
үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Д.Цэрэнням(Сургуулийн захирал)
Б.Энхмэнд (Цэцэрлэгийн эрхлэгч)
Х.Энхжаргал (Соёлын төвийн дарга)
А.Батжаргал(Талын Илч ОНӨААТҮГ-ын дарга)
Ч.Отгонцэцэг (Байгаль орчны мэргэжилтэн)

Нарийн бичиг:

2. Дунд хугацааны төлөвлөгөөг хэрэгжүүлэн хагас, бүтэн жилээр тайлагнан ажиллахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ГАНБАЯР



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 26 өдөр

Дугаар А/150

Баянтал сум

Малын 2023 оны хагас жилийн тооллогыг
зохион байгуулах комисс томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.23, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.в, 20 дугаар зүйлийн 20.2, 21 дүгээр зүйлийн 21.3, Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/159 тоот Захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрөөс 06 дугаар сарын 06-ны өдрийг дуустал хугацаанд сумын нутаг дэвсгэрт малын 2023 оны хагас жилийн тооллогыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга

Э.Эрхэмбаатар

(Засаг даргын орлогч)

Гишүүд:

Э.Түмэн-Эрдэнэ

(Лүн багийн Засаг дарга)

Т.Ган-Эрдэнэ

(Их уул багийн Засаг дарга)

Ц.Болдбаатар

(ЗДТГ-ын жолооч)

Нарийн бичгийн дарга:


Л.Отгонпүрэв

(ЗДТГ-ын Санхүү албаны дарга)

2. Тооллогод шаардагдах газрын маршрутыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.


3. Тооллогыг товлосон хугацаанд зохих журмын дагуу зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг комиссын дарга(Э.Эрхэмбаатар)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ГАНБАЯР

БАЯНТАЛ СУМЫН ИХ УУЛ БАГИЙН ХАГАС ЖИЛИЙН МАЛ ТООЛЛОГЫН МАРШРУТ



МАРШРУТ ГАРГААСАВ
 БАЯНТАЛ СУМЫН ИХ УУЛ
 БАГИЙН БАСАТ АРГАА
 Т. ГАН-ЭРДЭНЭ
 2023.05.23
 ХНТ 197 км

ГОЛБОМБЭЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 26 өдөр

Дугаар 4/51

Баянтал сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.17, 59.1.23, Засаг даргын шийдвэр 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 14.2.3, Төсвийн шууд захирагч түүний бүрэн эрхийн тухай хуулийн 16.5.5, Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.3, 2.1.4, 2.1.5, 2.1.6, 4.1 4.2-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засаг даргын зөвлөлийн 2023 оны 05 дугаар сарын 22-ны эдрийн 04 дүгээр ээлжит хурлаар дэмжигдсэн 645.0 /Зургаан зуун дөчин таван/ мянган төгрөгийг 1 дүгээр хавсралтаар, 10,000.00/ Арван сая/ төгрөгийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Дээрх зардалд шаардагдах 645.0 /Зургаан зуун дөчин таван мянган төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгөөс 10,000.00/ Арван сая/ мянган төгрөгийг хур хог хаягдал орчны бохирдолын зардлаас тус тус зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын санхүү албаны нягталан бодогч (Х.Ариунгуа)-д зөвшөөрсүгэй.

4.Дээрх ажилд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга /В.Гантуяа/-д үүрэг болгосугай.


ДАРГА



Б.ГАНБАЯР

Засаг даргын 2023 оны 15 сарын 28 өдрийн


115/ дугаар захирамжийн хавсралт



ЗАРДАЛЫН ЗАДАРГАА

| № | ЗАРЦУУЛАХ ТӨРӨЛ | ТӨСӨВТ ӨРТӨГ |
|---|-----------------|----------------------------|
| 1 | Жуух бичиг | 210.0 мянган төгрөг |
| 2 | Өргөмжлөл | 435.0 мянган төгрөг |
| 3 | Бүгд | 654.0 мянган төгрөг |

Засаг даргын 2023 оны 5 сарын 26-дрийн
15/ дугаар захирамжийн хавсралт



ЗАРДАЛЫН ЗАДАРГАА

| № | ЗАРЦУУЛАХ ТӨРӨГ | ТӨСӨВТ ӨРТӨГ |
|---|--|----------------------------|
| 1 | Мод тарих-70% Тохиожилт-30% Урамшуулал | 4,400,000.00 мянган төгрөг |
| 2 | Мод худалдан авах | 3,000,000.00 мянган төгрөг |
| 3 | Бусад зардалд | 2,600,000.00 мянган төгрөг |
| 4 | Бүгд | 10,000,000.00 |



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/52

Баянтал сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын "Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээг байгуулах ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Э.Эрхэмбаатар (Засаг даргын орлогч)

Гишүүд:

Д.Цэрэнням (Сургуулийн захирал)

Х.Энхжаргал (Соёлын төвийн дарга)

Б.Энхмэнд (4-р Цэцэрлэгийн эрхлэгч)

Э.Баасангарав (Эрүүл мэндийн төвийн

даргын үүрэг гүйцэтгэгч)

Э.Түмэн-Эрдэнэ (Лүн багийн Засаг дарга)

Т.Ган-Эрдэнэ (Их-Уул багийн Засаг дарга)

Ч.Отгонцэцэг(Нийгмийн бодлогын

мэргэжилтэн)


Нарийн бичгийн дарга:

В.Гантуяа (Засаг даргын Тамгын

газрын дарга)

2. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч Э.Эрхэмбаатар-д даалгасугай.

ДАРГА



Б.ГАНБАЯР